

Шүүх шинжилгээний ерөнхий газрын
2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн
тоот албан бичгийн нэгдүгээр хавсралт

05/12760

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ДОТООД ХЯНАЛТ, АУДИТЫН ГАЗАР



ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Хяналт-шинжилгээ хийх журам”, 2 дугаар хавсралт “Үнэлгээ хийх журам”-ын дагуу Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Шүүх шинжилгээний байгууллагад хамаарах ажил, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж үнэллээ.

Үнэлгээг удирдлагаас өгсөн үүргийн дагуу тус газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн ахлах дэслэгч Т.Буяндэлгэр, цагдаагийн хошууч Т.Нурмаа, мэргэжилтэн, цагдаагийн ахмад Э.Ижилцэцэг нар Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ хийж, үнэллээ.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.5.6. “Шүүх шинжилгээний үйл ажиллагаанд судалгаа, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шинэ төрлийн шинжилгээний чанар, үр дүнг олон улсын жишигт хүргэж, шүүх шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална.” гэсэн зорилтын хүрээнд “Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах МОН-22” төслийг хэрэгжүүлэх арга хэмжээг 2025 онд 30 хувьтай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Шүүх шинжилгээний байгууллагад хамаарах ажил, арга хэмжээний хэрэгжилт

Хэрэгжих хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа арга хэмжээний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Зорилт хэрэгжүүлэх арга хэмжээ	Заалтын тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь					Дундаж хувь
			х/б	0-29	30-59	60-84	85-с дээш	
1	4.1.5.6. Шүүх шинжилгээний үйл ажиллагаанд судалгаа, техник, технологийн ололтыг нэвтрүүлж, шинэ	Чадавхжуулах сургалт	1	-	-	-	1	100

төрлийн шинжилгээний чанар, үр дүнг олон улсын жишигт хүргэж, шүүх шинжилгээний байгууллагын бие даасан, хараат бус байдлыг хангаж, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаална. 1083. “Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах МОН-22” төслийг хэрэгжүүлэх	Барилга байгууламжийн зураг, төсвийг боловсруулж, батлуулах	1	-	-	-	-	1	100
	Төсөл хэрэгжүүлэх газарт инженерийн дэд бүтэц байгуулах	1	-	-	-	1	-	75
Дундаж		3	-	-	-	1	2	92

(Төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав.)

Төслийн хүрээнд барилга байгууламжийн зураг, төсвийг боловсруулж, батлуулсан байна. Хууль зүй, дотоод хэргийн яам 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдөр төслийн зөвлөхтэй байгуулсан гэрээнд төслийн хэрэгжүүлэх хугацаанд 80 алба хаагчийг БНСУ-ын Сөүлийн үндэсний их сургуульд чадавхжуулах сургалтад хамруулахаар тусгаснаас 2025 оны байдлаар 40-н алба хаагчийг хамруулсан байна.

Төсөл хэрэгжүүлэх газарт инженерийн дэд бүтэц байгуулах арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлагийн Худалдан авах ажиллагааны газар “Шүүх шинжилгээний ерөнхий газар”-ын үйлчилгээ, контор, шинжилгээний барилга орц, гарцын гүүрний байгууламж (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 21 дүгээр хороо) тендерийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зарлаж, тус тендерийн гүйцэтгэгч шалгаруулсан боловч Сангийн сайдын 01/10803 дугаартай “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу 2025 оны санхүүжилтийг түр хойшлуулсан тул гэрээ байгуулаагүй бөгөөд төсвийн тодотголоор хасагдсан.

Мөн төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулагдсан боловч тендер зарлагдаагүй байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшин

Хэрэгжих хугацаа дуусаагүй буюу хэрэгжиж байгаа арга хэмжээний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

№	Зорилт хэрэгжүүлэх арга хэмжээ	Заалтын тоо	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь				Дундаж хувь	
			х/б	0-29	30-59	60-84		85-с дээш
2	Шүүх шинжилгээний дүгнэлттэй холбоотой гомдлын тоог бууруулна.	1	-	-	-	-	1	100
Дундаж		1	-	-	-	-	1	100

Шүүх шинжилгээний байгууллагад 2025 онд шүүх шинжилгээний дүгнэлттэй холбоотой 12 гомдол ирсэн байна.

ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд Шүүх шинжилгээний байгууллагын хүчин чадлыг сайжруулах МОН-22” төслийг хэрэгжүүлж байна.

Сангийн сайдын 2025 оны 71 дугаартай тушаалаар төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтэц, орон.тоог баталж Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2025 оны А/102 дугаар тушаалаар нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн Удирдах хороог, 2025 оны А/101 дүгээр тушаалаар Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийг тус тус байгуулсан байна.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 218 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан Шүүх шинжилгээний байгууллагад хамаарах хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд 2025 онд хийсэн ажлын үр дүнгийн хэрэгжилтийн явцад үнэлгээ хийхэд үнэлгээ 92 хувь буюу үр дүнтэй байна.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 218 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Шүүх шинжилгээний байгууллагад хамаарах Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшин 2025 онд 100 шинжилгээнд гаргах гомдлыг 21 байхаар төлөвлөсөн байхад тайлант хугацаанд 12 гомдол ирсэн байгаа нь үнэлгээ 100 хувь буюу үр дүнтэйгээр тус тус үнэлэгдэж байна.

Цаашид Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах төсөл хэрэгжүүлэх газарт инженерийн дэд бүтэц байгуулахад шаардагдах санхүүжилтийг нийслэлийн төсвөөс бий болгох, төслийн ерөнхий гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны үйл ажиллагааг сайжруулах шаардлагатай байгаа саналыг тус тус илтгэн танилцуулж байна.

_____оОо_____

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРСЭН ТҮВШИН

(Шүүх шинжилгээний ерөнхий газар)

Засгийн газрын 2024 оын 12 дугаар сарын 18-ны өдрийн
218 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

Хамаар ах зорилт	Үр дүн	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжи х нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин				Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэ л цуглуула х давтамж	Хэрэгжилт
					2025	2026	2027	2028			
	Хөтөлбөрийн үр дүн										
4.1.5.6	Шүүх шинжилгээний дүгнэлттэй холбоотой гомдлын тоог бууруулна.	100 дүгнэлтэд ногдох гомдол	Тоо	23	21	19	17	15	100 дүгнэлтэд ногдох гомдлоор тооцно.	Жил тутам	Шүүх шинжилгээний байгууллагад 2025 оны 11-р сарын байдлаар нийт 114,472 шинжилгээ хийж, дүгнэлт гаргаснаас дахин шинжилгээ 783 хийгдсэн байна. Тайлант хугацаанд иргэдээс 25 өргөдөл, хүсэлт ирүүлснээс шинжээчийн дүгнэлттэй холбоотой 12 гомдлыг хүлээн авч, тухай бүр судлан шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгч ажилласан. Энэ нь тус байгууллагад хийгдсэн 100-н дахин шинжилгээ тутамд 2 гомдол ирсэн байна.

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР